



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 778

Улаанбаатар хот

Хөрөнгө акталж данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2, 6.3.4, 6.4.3, 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Завхан, Хөвсгөл аймгуудын Хүнс, хөдөө аж ахуйн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 9 нэрийн нийт 6,661,784.00 (зургаан сая зургаан зуун жаран нэгэн мянга долоон зуун наян дөрвөн) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Хөвсгөл аймгийн хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Г.Баттулга, Завхан аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Н.Батбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Акталж, данснаас хассан хөрөнгийг сэлбэгээр худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Акталж, данснаас хассан тээврийн хэрэгслийг улсын бүртгэлээс хасуулж, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан холбогдох мэдээ, тайлангийн маягтын хамт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

13201733

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
 газрын 2020 оны 14 дугаар сарын 28-ны өдрийн
 778 дугаар тогтоолын хавсралт

**АЙМГУУДЫН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД
 БҮРТГЭЛТЭЙ АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ (ш)	Нэгжийн үнэ	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл	Хуулийн этгээдийн нэр
					(төгрөг)	
1	Анжис	2003.06.27	1.00	151,755.00	151,755.00	Хөвсгөл аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар
2	Төмс суулгагч	2003.06.27	1.00	1,196,530.00	1,196,530.00	
3	Жижиг оврын трактор	2008.12.31	1.00	1,910,000.00	1,910,000.00	
4	1 голтой чиргүүл	2003.06.27	1.00	1,206,259.00	1,206,259.00	
5	Мод, үхрийн нүд	2018.12.31	2.00	5,590.00	11,180.00	
6	Мод голт бор	2018.12.31	1.00	16,760.00	16,760.00	
7	Гал командын байр	1971.07.07	1.00	24,500.00	24,500.00	Завхан аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар
8	Нүүрсний хашаа	1999.07.01	1.00	2,128,000.00	2,128,000.00	
9	Хайс	1999.07.01	1.00	16,800.00	16,800.00	
Нийт дүн					6,661,784.00	-
					(зургаан сая зургаан зуун жаран нэгэн мянга долоон зуун наян дөрвөн)	